

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Соном	Дугаар	L178
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Чандмань
Төрсөн газар	Чандмань сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Өлзийт булагийн хийд	Сүм хийдийн дугаар	ГАЧН 098
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 22	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Чандмань сумын **Өлзийт булагийн хийд**

Өлзийт булагийн хийд 37 оноос өмнө 30 оноос хойш байгуулагдсан юм гэнэ лээ. Тэрнээс хойш хэсэг 60, 70-аад хүүхэд байсан, 4 дугантай, би өөрөөтэрэн дээр 17 жил суусан хүн. Баруун дуган, Цогчэн дуган, ял дуган, дарь эхийн дуган гэдэг ийм 3 дугантай, 6 жастай, тэгээд хонь, ямаа нэлдээ хонь нь 2, 3 мянган хоньтой, ямаа нь 2 мянгаад, 2, 3 зуун адуутай, 100-гаад тэмээтэй тийм хийд байсан юм даа. Их сайхан өвс ус сайтай Чойр юм байхгүй, ерөөсөө дандаа уншлага 10 **хангал**,сахиус тахидаг, ойр зуурынх нь юмыг яадаг тийм л юм байсан.

Асуулт:-Гүрэм, засал хийдэг байсан уу?

Хариулт:-Тийм.Хурал нь зуны хурал хурдаг. Лам нар, гэлэнгүүд нь хийнэ шүү дээ.Тэрний дараа өвөл болохоор зулын хурд гээд зул сарын 25-ны юу байдаг. Энүүгээр 7 хоног хурдаг,тэгээд **цанжид** ерөөлийн хурал нь өвлийн **дунд сарын 24-нөөс цанжидын** хурал гэж дандаа л ерөөл магтаалын хурал хийгээд, тэгээд цагаан сараас өмнө 7, 8 хоногийн өмнөгүйдэр хураад 10 **хангалыгаа**, тэгээд сор залаад ийм л юм хийдэг ийм л хүрээ байсан юм.

Асуулт:-Та хийдийнхээ том лам нарыг ярьж өгөхгүй юу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Том лам **нар нь Баасан** гэлэн гэж жинхэнэ ловон лам нь байсан юм. Дандар гэлэн гэдэг нь да лам байсан юм, тэрний наадуул нь **дооши** нь 10-аад гэлэн лам нар байдаг байсан юм.

Асуулт:-Үлдсэн нь дандаа жижиг хүүхдүүд

Хариулт:-Жижиг хүүхдүүд, банди нар дандаа ном үзэж байгаа тийм улсууд байсан юм.60, 70-аад хүн байсан.

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан бол?

Хариулт:-Лхам, баруун жас чинь улаан сахиус, ядам, Цогчэн нь бол**Лхам** ийм. Дарь эх гэдэг нь **махгал шүтдэг**, хар морь сэтэрлэдэг ийм л байсан юм даа.

Асуулт:-**Жод, лүйжин** тавьдаг лам нар байсан уу? улааны урсгал бас байсан байх?

Хариулт:-**Жод, лүйжин** тавьдаг лам нар байсан. Манай аавын ах Нял үнзад гэдэг хүн байсан.Зод тавьдаг.Тэрнээс өөр зод тавиад байдаг хүн байхгүй байсан байхаа.

Асуулт:-Хийдэд номоо барладаг бар байсан уу?

Хариулт:-Бар байсан байхаа, би тэрнийг сайн мэдэхгүй юм. Бас өөрөө бага болоод.

Асуулт:-Ганжуур, **Данжуур** том хөлгөн судрууд байсан уу? Ганжуур,**Данжуураа**хаанаас авчирсан гэнээ, тэр хийд?

Хариулт:-Баруун зуу эндээс л авчирсан юм гэсэн.

Асуулт:-Тэр үед Баасан гэлэн гэдэг хүн хийдийн хамба нь байсан юмуу?

Хариулт:-Тийм, баригдаад явсан.

Асуулт:-Тэр хийдийн **Өлзийт булаг** хийдийн лам нар ямар уулыг тахидаг байсан юм бол?

Хариулт:-Байдаг байхаа, цаад талын **Ноёгун** гэдэг уулыг тахиж байсан. Манай энэ Чандмань сүм чинь ерөөсөө хоёр талдаа хоёр уул байдаг юм.Энэ нь чандмань уул, нэг нь ард сүмийн **Самдандамба** гэдэг уул.Энийг улаан сахиусны орон, тэрнийг **Лхамын** орон.Ийм нутгийнхаа хоёр захад хоёр уултай.

Асуулт:-**Өлзийт булаг** хийд энэ хоёр уулаа тахидаг байсан уу?

Хариулт:-Тахидаг юм нь тэндээ байсан.**Ноёгун** гэдэг энэ талд ийм хөх уул бий.Тэрнийгээ тахидаг.

Асуулт:-Яаж тахидаг байсан юм бол, цагаан идээгээр тахидаг байсан юмуу?

Хариулт:-Дандаа цагаан идээгээр. Энэ ууланд зочид цонхор өргөнө.**Энд** бол сүү, цайны дээж өргөхөөсөө**урдаар** архи өргөж байж сүүлд нь тахидаг ийм уул байсан.Тэр **лхамынханд** бол шүүс тавихгүй ээ, цагаан идээгээр тахидаг байсан.

Асуулт:-Овоогоо **тахичихаад** наадам хийдэг байсан уу? Бөх барилдах уу?

Хариулт:-Хэдэн бөх барилддаг, морь уралдаад байсан ч юм байхгүй. Хүрээн дээр банди нар барилдаад.

Асуулт:-Та хэдэн онд **Өлзийт булагийн** хийдэд шавилж суусан бэ?

Хариулт:-Би 7 настай. Хэдэн он байсан мэдэхгүй.Тэрнээс хойш 17-той гарав уу даа.Хүрээ тарахад л.

Асуулт:-Ном үзэж байсан тухайгаа ярих уу? Цуг сурч байсан **хүүхдүүдийнхээ** тухай, яаж ном үзэж байсан юм?

Хариулт:-Өглөөдочоод багшаараа **заалгачихаад** тэрнийгээедөрт 4, 5 мөрийг заалгаад тэрнийгээ өнөөдөр нь тогтоочихоод маргааш нь очиж **нөгөөдөхөө**шалгуулаад, дахиж заалгуулаад ийм л юм хийдэг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Манаач нь өөрөө хувилгаан ламтай.Гунгаа гэдэг хүн байсан, тэгээд надтай чацуу хүн байсан, нас бараад хэдэн жил болж байна.

Асуулт:-Цам,**Майдар** гардаг байсан уу?

Хариулт:-Үгүй, байхгүй. Цам**Майдар** гарахгүй, хүн хүч гүйцэхгүй.

Асуулт:-Тэр үед хятадын наймаачид байсан уу?

Хариулт:- Хааяа нэг ирээд явна уу гэхээс үргэлж байдаггүй. Хятад угаасаа оруулдаггүй байсан.

Асуулт:-Барилга байшин нь юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Дандаа шавар.

Асуулт:-Оройг нь модоор хийгээд.

Хариулт:-Тэгсэн. Нэг модон дуган байсан. Тэр нь хэлмэгдлээр чинь аваачиж бариад дэлгүүр хийсэн байсан, сүүлд нь шатсан гэсэн байхаа.

Асуулт:-Хэлмэгдлээр **Өлзийт булагийн** хүрээний бурхан шүтээн нь яасан юм бол?

Хариулт:-Тэр чинь тэр чигээрээ бүтнээрээ байж байсан. Тэрнийг чинь гуулин бурхан ч гэсэн асар их хэмжээнийх байсан. Тэгээд тэрнийг дотоод яамныхан ирээд хүрээний**энэ рүү** гүнзгий ганга байдаг юм. Тэрүүнд аваачаад хуу шатаачихсан юм гэнэ лээ.Тэгээд том гуулин **бурхануудаа** яасан.Манайх тэр алтан зууг сүйд болж аваад айлын байшинд, **хогонд** дотор ч хаяж байгаад авч гарсан юм гэнэ лээ. Тэр нь сүүлд нь бас олон дотроосоо тэрнийг чинь матаад зуугаа үлдээчихсэн байж байна.Ингэж хойно хойноо дотоодын хамгаалахад хэлээд тэрнийг нь хурааж аваад явчихсан.Тэгээд тэр бурхан байхгүй болсон.

Уг нь хүрээ хийдийг жаахан тохижуулаад аваад явбал хойдүеийнхэнд их л хэрэгтэй юм. Одоо тэгээд энэ чадахгүй юм байлгүй дээ.

Асуулт:-**Өлзийт булагийн** хийд яг хэдэн оны үед тарж байхгүй болов?

Хариулт:-37 оны үед байхгүй болсон.

Асуулт:-Таныг 17, 18 насны орчим настай байхад байхгүй болсон уу?

Хариулт:-Тэгсэн. Тэгээд л хүрээ чинь тэр чигээрээ эзгүй хоцроод доогуурх банди нар хуу хөдөө гараад, тэгээд эзгүй **тэрэн** дээр чинь 2, 3 хүн **хүрч ирээд бурханыг** нь шатааж хийгээд,тэгээд хураахыг нь хурааж аваад, бүх малыг нь хурааж аваад тэгээд алга хийчихсэн.

Асуулт:-Хүрээ тарсны дараа та ямар ажил хийв.

Хариулт:-Би тэрнээс хойш цэрэгт яваад.

Асуулт:-Цэргийн албыг хаана хаасан бэ?

Хариулт:-Би **Тамсагийн** 6, Матадын 8-р **дивизид**

Асуулт:-Дайны үед хаасан уу?

Хариулт:-Тэгсэн, дайны үед **Тамсагийн** 6-д хаагаад, сүүлчийн 45 оныхыг Матадын 8-р **дивизид**.

Асуулт:-Тэрнээс хойш мал малласан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тэрнээс хойш мал ч малласан юм байхгүй, агент хийгээд. 30-аад жил агент хийлээ.Хоршоодын 14, 15-р их хурал, Худалдааны тэргүүний сайчуудын 2-р зөвлөлгөөн Улаанбаатарт олон дахин хуралд явлаа. Худалдааны тэргүүний ажилчин ч болж үзлээ,тэгээд сүүлд нь одон цэргийн гавьяаны улаан тугийн одон, байлдааны хүндэт медаль, хөдөлмөрийн хүндэт медаль нийлсэн 17, 18 их, бага тэмдэг авлаа.

Асуулт:-Соном гуай та хэлмэгдүүлэлтийн талаар ярьж өгөхгүй юу, танай хамаатан садан хүмүүс хэлмэгдэж байсан хүн бий юу?

Хариулт:-Манай аавын хоёр ах дүү гурвыг аваачиж Завханд авсан юм. Нэгийг нь 36 оны 6 сарын 10-нд манай аавыг 30 хүнтэй аваачиж хороосон байна лээ, би тэр бичгийг нь үзсэн. 2 ахыг нь 6 сарын 30-нд 90 хүнтэй аваачиж хороосон байна.Ингэж алсан юм байна лээ.Манай **аав бол** зүгээр жирийн мал, гөрөөс ан хийдэг жирийн хар хүн.Ноён хүний феодал, хар феодал гэж хэлээд тэгээд тэр гурвыг чинь аваачиж алсан.Нэг ах нь хүрээний лам унзад хүн гэж.

Асуулт:-Ямар хүрээний, хэн гэдэг хүн бэ?

Хариулт:-**Өлзийт булагийн** хүрээний Нял унзад гэдэг хүн байсан юм. Наадах ах нь 70 хэд хүрсэн Буюн гэдэг хөгшин байсан.Зүгээр авгай хүүхэд ч үгүй, гэрт л байдаг байсан.Зүгээр хөдөөний хүн.Тэрнийг ноёны уг гэж хэлээд аваачаад алчихсан.Ийм 3 хүнийг алсан даа.

Асуулт:-Танай аавыг хэн гэдэг хүн гэнээ?

Хариулт:-Гончиг гэдэг хүн байсан юм.

Асуулт:-Гончиг гэж ноён удмын хүн байсан юм байна шүү дээ.

Хариулт:-Тийм.

Асуулт:-Цагаатгалд орсон уу?

Хариулт:-**Хууд (бүгд)** цагаадаад сая, сая төгрөг өгсөн гэсэн.